



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 8/56

Хашаат

Эрх зүйн хөтөч багийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59.1.23, Хууль зүйн дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 124 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Сум дүүрэгт эрх зүйн хөтөч /ухуулагч/-ийн ажиллах журам"-ын 1.3, Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нийт иргэдэд хууль тогтоомжийг сурталчилах, таниулах хууль эрх зүйн сургалт зохион байгуулах эрх зүйн хөтчөөр ажиллах албан хаагчдыг шинэчлэн томилсугай. Үүнд:

1. Б.Цэрэнбямба - Насан туршийн боловсролын багш
2. Г.Гэрэлтуяа -Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн
3. С.Лхамнормаа – Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн
4. Б.Сэлэнгэ – Хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч
5. С.Оюун-Эрдэнэ – Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан
6. О.Энхсаруул – Соёлын төвийн өвийн ажилтан

2. Эрх зүйн хөтөч багийн гишүүдтэй гэрээ байгуулж, ажил үүргийн хуваарьтай болгож ажлыг хагас, бүтэн жилээр төлөвлөн зохион байгуулан эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын үр дүнг тогтмол хэлэлцэж, эрх зүйн хөтчүүдийг удирдлагаар хангаж, хамтарч ажиллахыг Тамгын газрын дарга (Ё.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ОДБАЯР

